



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг зөвлөлийн дарга /Ч.Однасан/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны А/55 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150500017

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны
өдрийн 1109 дугаар тушаалын хавсралт



ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛ

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга:	Орлогч дарга	Ч.Однасан
Нарийн бичиг:	Тооцооны нягтлан бодогч	Г.Халиунаа
Гишүүд:	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Т.Итгэл
	Цахилгааны инженер	Б.Батсүрэн
	Байр хариуцсан менежер	М.Мөнхцэцэг
	Зоогийн газрын менежер	Б.Эрдэнэтөгс
	Нярав	Г.Рэнцэнханд